

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-28
1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4-11
2. Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт	11-28

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 26-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Батболд, Б.Чойжилсүрэн;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Х.Болормаа, Г.Дамдинням,
П.Мөнхтулга;
Эмнэлгийн чөлөөтэй: З.Мэндсайхан.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Дэлгэрмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, Хуулийн референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, Ж.Баясгалан нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Батбаяр, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 13 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 12 цаг 15 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Байнгын хорооны хуралд ирэх ёстой 25 гишүүнээс 14 ирсэн байна. Батбаяр гишүүнийх яагаад орохгүй байгаад байна. Орчих тэгээд би хувийг нь өөрийн чинь орсноор хэлээдэхье. Ахиад үз. Ширээгээ солиод үзэх юм уу. 14 гишүүн ирсэн, 56 хувийн ирцтэй байна. Ирц хангалттай байгаа тул 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Бүртгүүлээд зааланд байхгүй байгаа гишүүд орж ирье. Ирц танилцуулъя. Т.Аубакир, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, Б.Түвшин, Д.Батбаяр, Д.Пүрэвдаваа, Д.Цогтбаатар, Ж.Батжаргал, Г.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн нарын гишүүд өнөөдрийн хуралд бүртгүүлсэн байна.

Хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Би 2 асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Эхний асуудал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд хэлэлцэх эсэх асуудал байгаа.

2 дахь асуудал Улсын Их Хурлын даргын 192 дугаар захирамжаар байгуулагдсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулах байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Бямбацогт гишүүн танилцуулах юм уу, Сангийн сайд танилцуулах юм уу. Учрал шүү дээ. Бусад сайд нараа ер нь оруулъя. 5 сайд Байнгын хорооны гишүүн юм байна. 1 л сайд бүртгүүлсэн байна. Аубакир сайд. Бусад нь бүртгүүлээгүй байна. Засгийн газрын гол ажил учраас төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ сайд нар өөрсдөө байх хэрэгтэй.

Эхний асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028-ны төсвийн төсөөллийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. С.Бямбацогт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Дэлгэрмаа Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028-ны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Учрал сайд байхгүй байгаа юм байна. Тэгвэл Бямбацогт сайд танилцуулъя. Бямбацогт сайдын микрофон.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Учрал сайд гадаад томилолттой Беларусь улсад ажиллахаар явсан байгаа. Тийм болохоор орлож өнөөдөр танилцуулгыг хийе.

Манай Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд 7,4 хувь, 2024 онд 4,9 хувь байсан бол 2025 оны эхний улиралд 2,4 хувь болж буураад байна. Нийт экспорт 2025 оны эхний 5 сард 5,4 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 931 сая ам.доллараар, төсвийн нийт орлого 2025 оны эхний 5 сард 11,4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 1,3 их наяд төгрөгөөр буураад байна.

Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ Гаалийн ерөнхий газраас зарладаг албан статистик мэдээллээр 2025 оны эхний 5 сарын байдлын байдлаар дунджаар 72 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар унаад байна. Экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас 2025 онд нэгдсэн төсвийн орлого, төсвийн хүрээний мэдэгдэлд заасан орлогын доод хэмжээнд хүрэхгүй байхаар байгаа бөгөөд мөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх зорилгоор төсвийн тодотгол хийж байгаа тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төсөлд 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,2 их наядаар бууруулж, нөгөө талд нь төсвийн зарлагыг 1,9 их наяд төгрөгөөр бууруулж, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 365 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тусгаж байна.

Уг хуулийн төсөлд нэгдсэн төсвийн 2026-2027 оны төсөөлөл шинэчлэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай тул уг хуулийн төслийг дагах хуулиар өргөн мэдүүлсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайдад баярлалаа. Уг нь төсвийн хүрээний мэдэгдэл учраас адаглаад Байнгын хорооны гишүүн сайд нар ормоор байх юм. Нөгөө сахил хүртээд шал дордов гэгчээр тэгээд сайд болонгуутаа уг нь идэвхтэй оролцдог байсан сайд нар маань алга болчих юм.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Баясгалан гишүүнээр тасаллаа. Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Ажлын хэсгээс 2 зүйл тодруулмаар байна. 1 дүгээрт нь бол инфляцыг тооцсон аргачлалын талаар тодорхой мэдээлэл авмаар байна. Миний хувьд бол инфляцыг буруу тооцсон гэж үзэж байна. Учир нь гэвэл 2025 оны 5 дугаар сарын байдлаар инфляц 8,3 хувьд хүрсэн. Гадуур бодит үнийн өсөлт ялангуяа цахилгааны үнийн өсөлт, түрээс, нийтийн тээвэр, хувцасны бүлгийн өсөлт тогтвортой өндөр түвшинд байна. Махны үнэ улирлын дундаж хандлагаас давж өссөн байна. Энийгээ та бүхэн маань яаж тайлбарлах вэ.

Мөн дараагийн дугаарт 2024 онд зээлийн үлдэгдэл 36,8 их наяд төгрөг гэж та бүхний тараасан материалд байна. Энэ нь сүүлийн 10 жилийн дээд хэмжээ 35,5 хувиар өссөн. Мөнгөний нийлүүлэлт 15,2 хувиар өссөн. Эдгээр хүчин зүйлүүд инфляцад хэрхэн нөлөөлж байна. Ингээд эдийн засагч хүний хувьд эдгээр тооцоонуудыг харахаар инфляцыг та бүхэн маань хэт багаар төсөөлөөд байна. Бодит байдлаа буруу үнэлээд байна гэсэн ийм байр суурьтай байна. Тийм учраас энэ дээр та бүхэн маань тодорхой бөгөөд мэргэжлийн үүднээс тайлбарлаж, тоон мэдээллийг өгнө үү.

Ц.Даваасүрэн: Асуултад хэн хариулах вэ. 5 номер Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр инфляцыг 7,2 хувиар тооцсон байсан. Одоо өөрчлөлт оруулж инфляцыг 9,5 хувь байхаар 2,3 хувиар нэмэгдүүлж, энэ жил үнийн өсөлт нэлээн байж магадгүй гэж тооцож нэмэгдүүлж байгаа. Инфляцыг бол Үндэсний статистикийн хороо албан ёсоор тооцдог. Нийтдээ хэрэглээний үнийн сагсны 430 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнээ дунджаар нийлүүлж байгаад жигнэсэн дунджаар нь тооцдог. Энд ямар нэгэн хөндлөнгийн нөлөөлөл орох тийм боломжгүй байдаг. Тийм болохоор таны хэлж байгаа буруу, худлаа тооцдог гэдэг асуудал бол харьцангуй байхгүй болов уу гэж бодож байна. Үндэсний статистикийн хороо бол Монгол Улсын Их Хурлын дэргэдэх харьяа байгууллага. Хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. Засгийн газраас ямар нэгэн байдлаар бас инфляцыг өсгөөд тооцчих, эсвэл бууруулаад тооцчих гэж бас нөлөөлөх боломж байхгүй.

Махны үнийн тухайд бол ер нь жил болгоны өдийд мах бас нэлээн өндөр өсдөг. Мал онд ороод тарга тэвээр аваагүй энэ үед бас махны нийлүүлэлт нэлээн хомсоддог. Энэ үед үндсэндээ 6 дугаар сар, наадам хүртэл хугацаанд махны үнэ бас нэлээн өндөр өсөлттэй байдаг. Наадмын дараагаас харьцангуй үнэ бас тогтворжиж, буурах болов уу гэсэн тийм хүлээлттэй байгаа.

Ц.Даваасүрэн: Болсон уу. Тодруулъя. Пүрэвдаваа гишүүний микрофон.

Д.Пүрэвдаваа: Бямбацогт сайдаас нэг хүсэлт байна. Мэдээж Статистикийн ерөнхий газар ингээд хараат бусаар тооцож өгдөг л дөө. Тэгэхдээ бодитоосоо ялгаатай харагдаад байгаа юм л даа. Тэгээд энэ мөнгөний нийлүүлэлт 15, хувь, зээлийн үлдэгдэл 10 жилийн дээд хэмжээндээ хүрсэн 36,8 их наяд төгрөг байна гэдэг эдгээрийг та нар хэрхэн тооцсон талаараа мэдээлэл өгсөнгүй. Тэгээд би таны гарын үсэгтэй албан тоотоор яаралтай горимоор оруулж байгаа юм чинь яаралтай горимоор надад энэ инфляцыг тооцсон арга дээр танай Хэрэг эрхлэх газар хяналт тавиад, надад тооцоолсон аргачлалыг нь тайлбарласан ийм мэдээлэл авч болох уу.

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Инфляцыг тооцсон аргачлалыг танд бас би албан ёсоор бичгээр хүргүүлъя. Мөнгөний нийлүүлэлттэй холбоотой зээлийн үлдэгдэл нэлээн өсөж байгаа гэдэг зүйл дээр Батхүү дарга нэмээд хариулчих уу.

Ер нь бол зээлийн өсөлт өндөр байгаа. Мөнгөний нийлүүлэлт ч гэсэн 10 орчим хувь бас өсөж байгаа. Мөн бас Монголбанкнаас инфляцыг 6-8 хувьд барих зорилт тавьж байгаа. Энэ хүрээнд мөнгөний бодлогыг бас хатууруулах, чангаруулах ийм бодлого барьж ажиллаж байгаа юм байна лээ гэдгийг танд бас хэлье. Тэгээд Батхүү дарга нэмээд хариулчихъя.

Ц.Даваасүрэн: Батхүүгийн микрофон хэд байна. 4 үү. 4 номер. Тэр өмнө асуултад хариулаагүй зүйлүүд дээр нэмээд хариулчих. Тэр мөнгөний нийлүүлэлттэй холбогдолтой, инфляц, инфляцын тоо чинь ер нь тэгээд мөнгөний нийлүүлэлттэй уялдаж гарч байгаа шүү дээ. Тэгээд мөнгөний нийлүүлэлтийг нь ингээд харахаар 2 дахин өсчихсөн байгаад байдаг. Гэтэл инфляц чинь ингээд харахаар 30 хувьтай юм шиг яриад байдаг. Тэгээд энийг жоохон тодруулаач.

И.Батхүү: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Мэдээж инфляц бол гол инфляцыг барих чиг үүрэг нь Монголбанкны мөнгөний бодлогоос ихээхэн хамааралтай байдаг. Мөнгөний бодлогын хүрээнд мөнгөний нийлүүлэлт нь эдийн засгийн хэвийн өсөлтийг дагаад жилд ойролцоогоор 18-20 хувьтай хэвийн өсөлт ажиглагддаг. Яг энэ жилийн хувьд одоогийн байдлаар 10-15 хувь тан дээр байгаа 15,2 гэдэг тоотой байгаа. Мөнгөний нийлүүлэлтийг бол Монголбанк бодлогын хүүгийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, мөн иргэдэд болон бизнест олгож байгаа зээлийн тавигдах нөхцөл шаардлагыг өөрчлөх замаар хэсэг хугацааны лайгтайгаар удирдаж явдаг. Засгийн газрын зүгээс бол төсвийн сангийн бодлогынхоо хүрээнд зарцуулагдаж байгаа нийт хувийн хэвшилд олгогдож байгаа мөнгөнийхөө тооцооллыг бас давхар харж явдаг байгаа.

Засгийн газрын хувьд бол нийт макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд зорилтынхоо хувьд .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 4 номерын микрофон сунгая.

И.Батхүү: Засгийн газрын хувьд бол дунд хугацаандаа инфляцыг үе шаттайгаар бууруулах чиглэлээр 2 талын мөнгөний болон сангийн бодлогын уялдааг хангах чиглэлээр ажиллаж байгаа. Монголбанктай бас байнгын үйл ажиллагаагаа уялдуулж явж байгаа. Инфляцыг бууруулах нь бас санхүүгийн зах зээл дээр зээлийн хүүг бууруулах нийт иргэдийн бизнесийн орчныг сайжруулахад чухал ач холбогдолтой. Тантай бас санал нэг байна.

Ц.Даваасүрэн: Баясгалан гишүүн асуултаа асууя.

Ж.Баясгалан: Засгийн газраас өргөн барьсан төсөлд инфляц энэ оны эцэст өмнөх оны мөн үеэс өсөхөд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцын түрээсийн зардал болон хувцасны үнийн өсөлт голлон нөлөөлсөн гэж үзсэн байгаа. Тэгээд хэрэглээний үнийн түвшнийг төсөлд тусгаснаар бол 2025 онд 9,5, 2026 онд 7, 2027 онд 6,4 хувь байхаар ийм өөдрөгөөр төсөөлсөн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс инфляцыг 2026 онд дунджаар 8,2 хувь, 2027 онд 7,2 хувь, 2028 онд 6,8 хувь байхаар төсөөлөл гаргасан байгаа. Тэгээд өмнө нь би бас чуулган дээр хэлж байсан. Ерөөсөө уялдахгүй юм хоорондоо. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн бас мэдээлэл хийхдээ бол Монголбанкны төсөөллөөр инфляц бол энэ оны сүүлээр бол 2 оронтой тоо руу орж магадгүй. Бизнес эрхлэгчид бол одоо 2 оронтой тоонд орчихсон гэдгийг хэлээд байгаа шүү дээ. Тэгээд инфляцад нөлөөлөх нөлөөллүүдээ ер нь яг хэрхэн тооцсон юм. Жишээ нь нүүрсний үнэ буурахад гадаад валютын нөөцийн хэмжээнд нөлөөлөөд улмаар инфляцад бол нөлөөлнө. Тэгэхээр энэ эрсдэлийг яаж тооцсон юм. Валютын ханшийн өөрчлөлтийг яаж тооцсон юм.

2 дугаарт хүнсний барааны бүлгийн үнэ 9,2 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 9,7 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ бүр 16,4 хувиар өссөн байгаа шүү дээ. Цаашдаа ч энэ өсөх гээд байна. 2025 оны 5 сарын 26-ны байдлаар бол гол нэрийн барааны үнэ өмнөх оны мөн үеэс бол 1,3 хувь өссөн байна гэж байгаа. Тэгээд энэ 2025 он гэлтгүй, 2026 он дээр 1 дүгээр сараас эхлээд бид нар мэдэж байгаа. 2025 онд бол цахилгаан нэмэхэд л инфляц бол маш их хөдөлсөн. Гэтэл 2026 оны 1 сарын 1-ээс эхлээд аж ахуйн нэгж, дулааны тарифыг нэмнэ. Халуунд, хүйтэн ус, бохирын тарифыг нэмнэ. Энийгээ нэмнэ гэдгээ олон нийтэд зарлачихсан шүү дээ. Тэгэхээр энэ инфляцад тодорхой хэмжээгээр нөлөөлнө шүү дээ. Тэгээд энэ нөлөөлж байхад 7 хувь гээд дахиад ороод ирдэг. Тэгээд орж ирээд энэ жилийнх шиг ингээд л нөгөө 7,2 хувь байж байгаад 9,5 хувь гэж ингэж өөрчилж байгаа шиг дараа жил дахиад л энийгээ өөрчлөх юм уу. Ер нь жоохон бодитой тал руугаа оруулж болохгүй байгаа юм уу.

Энэ чинь 2026 онд бол бүр хамгийн наад зах нь л сая миний хэлдгээр энэ халуун, хүйтэн ус, тэгээд л дулааны үнэ нэмчихлээр чинь бүх л үйлчилгээ нэмэгдэнэ шүү дээ. Бүх л юмны үнэ дахиад өснө. Дахиад л инфляц бол 7 хувь байна гэдэгт бол ерөөсөө итгэхгүй байна. Энэ 3 асуултад хариулаад өгөөрэй.

Ц.Даваасүрэн: Ер нь ингэе: Дараагийн хэлэлцүүлэг дээр Статистикийн төв газрын дарга, Монголбанкны Ерөнхийлөгч 2-ыг оролцуулъя. Та хэд юу ч гэсэн хариулах уу. 5 Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Инфляцыг Үндэсний статистикийн хороо 430 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг 1 сагсанд хийгээд жигнэсэн дунджаар нь бас гаргадаг ийм аргачлалаар гаргадаг. Үндэсний статистикийн хороо бол бас Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага Засгийн газраас хараат бусаар үйл ажиллагаа нь явагддаг. Тийм болохоор инфляцыг тооцож байгаа аргачлал, инфляц гарч байгаа тоотой бол ямар нэгэн байдлаар Засгийн газраас нөлөөлж байгаа зүйл байхгүй гэдгийг 1 дүгээрт нь хэлье.

Ер нь инфляц бас өсөөд байгаа хэд хэдэн томоохон суурь шалтгаан байгаа. Мөнгөний нийлүүлэлт нэлээн нэмэгдэж байгаа. Хэрэглээний зээлийн өсөлт, төсвийн тэлэлт, мөн бас ханшийн сулрал гээд олон хүчин зүйлүүд байгаа. Энэ бүгд дээр үндсэндээ бас Засгийн газар тодотгол хийж байгаа 1 шалтгаан юуны төсвийн нийлүүлэлтийг бас бууруулъя. Төсвийн тэлэлтийг Монголбанк бас мөнгөний нийлүүлэлтээр мөнгөний бас хатууруулах бодлого, мөн бас хэрэглээний зээлийг бас хязгаарлах ийм бодлогууд хийж хэрэгжүүлж байна. Үүний бас тодорхой үр дүнгүүд бас гарах байх гэж найдаж байгаа. Цаашдаа бас төсвийн тодотгол хийж байгаа нэг шалтгаан бол үндсэндээ төсвийн бас тэлэлтийг хязгаарлах зорилгоор өөрөөр хэлэх юм бол цаад талд нь инфляцыг бас өсгөхгүй байх зорилгоор хийж байгаа гэсэн хэдий ч 7,2 хувь гэж 2025 онд тооцсон энэ тоо маань үндсэндээ бас нэлээн өсөх нь гэдгийг бас олж харж байгаа учраас бас 9,5 гэж, 2,3 хувиар энэ 2025 онд инфляц өсөх нь гэж төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирж байна. Тэгээд нэмэлт мэдээллүүдийг манай Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү хариулъя.

Ц.Даваасүрэн: Батхүү нэмье.

И.Батхүү: Сая Бямбацогт сайд гол төсөв дээр авч хэрэгжүүлж байгаа, тодотголын хүрээнд хэмнэгдэж байгаа зардлын инфляцын нөлөөллийг тайлбарлалаа. Үүнээс гадна ер нь Засгийн газрын харьяа байгууллага, хил, гаалийн байгууллага, тээвэр логистикийн байгууллага дээр инфляцад эергээр нөлөөлж болох тийм арга хэмжээнүүдийг идэвхтэй авч явуулахаар төлөвлөж байгаа. Аливаа түгжрэл саатал учруулахгүй байх, хурдан шуурхай нэвтрүүлэх, хил гаалийн шалгалтыг бууруулах гэх зэргээр. Мөн бас хөдөө аж ахуйн салбарт энэ жил бол эдийн засгийн өсөлт явагдаж байгаа. Өнгөрсөн 2, 3 жилийн хугацаанд бас байнгын уналттай явж ирсэн салбар маань сэргэж байгаа. Энэ салбар дээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, мах зэрэг бүтээгдэхүүний инфляцын дарамтыг бууруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд явагдаж байгаа. Энэ арга хэмжээнүүдийн гүйцэтгэлээр бас эерэг нөлөөллүүд хүлээгдэж байгаа гэж хэлж болно.

Ц.Даваасүрэн: Баясгалан гишүүн тодруулъя. Үгүй ээ, ер нь бол тэгээд л инфляц чинь манайд гол юм экспортын орлого, валютын нөөц, тэгээд валютын ханш л байгаад байгаа шүү дээ. Үүнээс шалтгаалж гол яваад байгаа. Баясгалан гишүүн тодруулъя.

Ж.Баясгалан: 3 дахь асуултдаа хариулт авъя. Энэ 2026 онд 7 хувь гэж зөвхөн энэ жилийнхийгээ хийгээд тодруулж байгаа биш, энэ чинь нийтээрээ ингээд ороод ирчихсэн байгаа шүү дээ. 2026, 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах гээд. Тэгэхээр 2026 оныхоо энэ төсөв дээр дулаан, цахилгааны үнэ наад захын дулаан цахилгааны үнэ нэмэгдээд байхад 7 хувь гээд энэ хэтэрхий

өөдрөг төсөөлөл биш үү. Энэ алдаатай төсөөлөл, алдаатай тооцоолол биш үү. Энэ дээр тэр дулааныхаа үнийг, бохирынхоо үнийг, цэврийнхээ үнийг, ард иргэдийнхээ яг нөгөө хэрэглээний үнийг өсөлтөөс болж байгаа энэ шалтгаанаа ер нь оруулж тооцсон уу.

Ц.Даваасүрэн: Суурь үнэ хөдлөх гээд байна. Суурь үнэ хөдлөхөөр бүх юм дагаж өснө гээд байна. Хэн хариулах вэ. 4 хариулъя. Ер нь бол төсвийн хүрээний мэдэгдлийг чинь Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж боловсруулж байгаа шүү дээ. 4.

И.Батхүү: Баясгалан гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Түрүүн дурдсан инфляцын түвшинд бол бид макро эдийн засгийн голлох үзүүлэлт учраас ер нь ийм байна гэдгээс гадна Засгийн газар өөрсдөө үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа гол байгууллагын хувьд бас зорилтот түвшин гэдгээрээ гаргаж явж байгаа. Хөндлөнгийн байгууллагууд ОУВС гэдэг ч юм уу, эсвэл тэр төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийгдэж байгаа тооцооллууд бол таамаглал тооцооллууд байгаа. Засгийн газар бол зорилт тавьж гэдэгтээ гол анхаарч байгаа.

Түрүүн бас Даваасүрэн даргын хэлж байгаа импортын инфляцад нөлөөлдөг гол зүйл болох валютын ханш, гадаад валютын албан нөөц зэргийг бас ямар түвшинд барьж явах вэ, ямар түвшинд хадгалах вэ гэдэг дээр бас Монгол банктайгаа хамтраад тодорхой тоонууд дээр зорилт тавьж ажилладаг. Энэ хүрээндээ бас бид зорилтот тоо гэж голлон ойлгож байгаа. Түрүүчийн дурдсан дулааны тариф нэмэгдэх хуулийн үйлчлэлийг хойшлуулсантай холбоотой нэмэлт нөлөөллийг бас тооцож байгаа. Түрүүн дурдсан 430 барааны .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ингээд дараагийн төсвийн хүрээний мэдэгдлийн хэлэлцүүлэг дээр Статистикийн төв газар, Монголбанкны Ерөнхийлөгчийг оролцуулаад, яг гол энийгээ боловсруулж гаргаж байгаа хүмүүсээс нь тайлбарыг нь авъя. Мөнгөний бодлого, статистикийн үзүүлэлтүүдийн талаар.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Үг хэлэх гишүүд алга уу. Үг хэлэх гишүүн алга байна. Би гишүүний хувьд зүгээр үг хэлчихье гэж бодлоо.

Тэгэхээр энэ одоогийн тулгараад байгаа төсвийн танах асуудал бол ерөөсөө төсвийн хэт тэлэлттэй холбоотой байхгүй юу. 2021 онд 2 дахин тэлж байхад би тухайн үед сайд байсан. Хэлж л байсан юм. Төсвийг ингээд шууд 2 дахин нэмж болохгүй. Экспортынхоо орлого өссөн хэмжээгээр ингээд нэмээд байж болохгүй гэж. Тэр үед 11 их наяд байсан. Одоо 30 их наяд, 33 их наядаас сая хасаад 30 их наяд. Тэгээд нэгэнт ингээд тэлчих юм бол энийг чинь хасаж авах боломжгүй болчихдог. Тэгээд одоо ингээд механикаар хасахаар яах вэ. Төсвөө зөв авч явсан төсвийн эрх захирагч нар хохирно. Нөгөө хулгайгаар орон тоогоо нэмчихсэн нь үлдэж байна шүү дээ.

Нөгөө талаар хамгийн их хэлмэгдэх гэж байгаа хүмүүс чинь төрийн албан хаагч нар болчихоод байна шүү дээ. Тэр халагдах гэж байгаа төрийн албан хаагч нар. Энэ буруу төлөвлөснийг чинь, төсөв өгсөж явсны чинь буруутан болчих гээд байна шүү дээ. Яг үнэндээ бол манай төрийн албан хаагч нарын ихэнх нь цалингийн зээлтэй байгаа. Тэгээд энийг яах юм бэ гэдгийг бас сайн давхар

бодолцохгүй бол үндсэндээ энэ цомхотголд өртөх гэж байгаа энэ хүмүүс бол эдийн засгийн хувьд нэлээн хүндэрнэ. Ядуурлын эгнээ рүү шилжих гэж байна гэсэн үг шүү дээ. Тэгээд энэ төсвийн төлөвлөлтийн асуудлыг цаашдаа бид нар бодож явахгүй бол олсныхоо хэмжээгээр нэмээд байдаг энэ асуудлыг л бид нар ер нь зогсоолгох ёстой. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын хууль, төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд л нэмээд яваад байгаа чинь бол бас энэ байхгүй юу. Тэмүүлэн бас хэлээд байдаг шүү дээ. Энийгээ өөрчлөөд, энэ тавьсан хязгаараа бид нар өөрсдөө уландаа гишгээд, дуртай цагтаа өөрчлөөд яваад байгаа учраас энэ төсөв чинь ингээд тэлээд байна. Дүрмээ мөрдөхгүй байна. Уг нь энэ чинь $\frac{3}{4}$ -аар ч юм уу өндөр босготой байх ёстой байсан юм. Харамсалтай нь даанч Үндсэн хуулийн цэц дээр аваачаад, энийгээ унагаж аваад, тэгээд одоо дуртай цагтаа төсвийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдээ өөрчилдөг, төсвөө нэмдэг энэ болгосны хар гайг өнөөдөр манай халагдах гэж байгаа төрийн албан хаагч нар үүрэх гэж байна гэдгийг бас хэлэх ёстой.

Тэгээд гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 80 хувиар төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхийг дэмжлээ.

2 дахь санал хураалт байгаа юм байна. Нөгөө дагасан хуулийн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дагасан хууль. 15 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 80 хувиар төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах асуудал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баясгалан нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.44 цаг.

Дараагийн асуудалдаа орёе.

Улсын Их Хурлын даргын 192 дугаар захирамжаар байгуулагдсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын

Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал дүгнэлт боловсруулах үүрэгтэй ажлын хэсгийн тайланг сонсох байгаа.

Улсын Их Хурлын даргын 25 оны 192 дугаар захирамжаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийг төсөвт үзүүлэх нөлөөллийг судлах, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн дарга Булгантуяа ажлын хэсгийн танилцуулгыг хийнэ. Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг миний бие ахалж, 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Бидний хувьд ажлын хэсэг гадаад зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт нийгмийн салбарын төсөв, эдийн засаг, дэд бүтцийн салбарын төсөв болон төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой мэдээлэлтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах 4 дэд хэсэг гарч ажиллаад, 4 дэд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг нэгтгэн нэгдсэн санал, дүгнэлтийг та бүдэд танилцуулж байна.

Манай ажлын хэсгийн 26 гишүүний бүрэлдэхүүнд нам намын төлөөлөл оролцож ажилласана.

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэмжих багийн бүрэлдэхүүнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Улсын Их Хурлын Тамгын газар, Төсвийн байнгын хорооны ажлын алба, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам гэх мэт Үндэсний аудитын газар гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Дээрх мэдээлэлтэй холбоотойгоор бид өчигдөр Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлын даргад хуулиа Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан байгаа.

Төсвийн цаглабартай холбоотой Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороогоор орчих учраас Төсвийн байнгын хорооны гишүүдэд ажлын хэсгээс ямар хуулийг Улсын Их Хурлын тухай хууль, дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан тухай та бүгдэд товч танилцуулъя.

1 дүгээрт Засгийн газраас төсвийн төслийг Монгол Улсын Их Хуралд 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн барьж байгаа. 11 дүгээр сарын 15-нд хуульчлан батлахаар байгаа. Улсын Их Хурлын намрын чуулган 10 сараас нааш эхэлдэггүй учраас 9 сарын 1-нд эрт өргөн барьсан ч гэсэндээ 10 сар хүртэл бид нар ямар нэгэн хэлэлцүүлэг хийх боломжгүй болчихоод байгаа юм. Тийм учраас бид Улсын Их Хурлын намрын чуулганы 9 сарын 15-ны өдрөөс эхлүүлж, төсвийн төслийг намрын чуулган эхэлсэн өдрөөс эхлэн хэлэлцүүлэхээр төсвийн төсөлтэй танилцах хэлэлцүүлгийг шинэ үе шат нэмэгдүүлээд, хуучин 4 үе шаттайгаар хэлэлцдэг байсан бол 5 үе шаттайгаар хэлэлцдэг болсон.

Ингээд Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг бас зөвхөн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонсож, ердийн хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу явдаг. Саяхан бид 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхэд та бүхэн санаж байгаа бол ердийн горимоор буюу Төсвийн байнгын хороо руу асуудлыг өгөөд ингээд л буцаад чуулган руу ордог. Бид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг дараа жилийн макро эдийн засаг, төсөв, эдийн засгийн чухал баримт бичиг учраас 4 үе шаттайгаар Улсын Их Хурлын бусад Байнгын хороонуудаар хэлэлцдэг болъё. Тэгээд үүнийг дагаж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт бас нэгдсэн хуралдаанаар сонсъё. Байнгын хороонуудаар хэлэлцье. Байнгын хороонуудаар гаргасан санал, дүгнэлтийг төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо нэгтгэн хэлэлцдэг болъё гэдэг ийм дэгийг оруулж ирлээ. Ингээд Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдаж хамтарсан санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганд танилцуулдаг болъё. Хэдийгээр төсвийн хүрээ дээр бол 9 том тоонд баталдаг ч гэсэндээ үүнийг ухаж, гишүүдээс асуух хэрэгцээ шаардлага бол маш их байгаа. Жишээлбэл яагаад орлогыг ингэж төлөвлөсөн юм. Нийгмийн даатгалын сангийн зардал яагаад нэмэгдсэн юм. Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой гээд үүнийг холбогдох Байнгын хороонууд нь нэмж асуултууд асуугаад, танилцуулга сонсох бас ийм эрх зүйн орчныг бий болголоо.

Мөн Монгол Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг болохдоо нэгдсэн төсвийн зарлагын дээд хэм хэмжээгээр баталдаг. Засгийн газар Улсын Их Хуралд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хамт өргөн мэдүүлээд, улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол баталдаг. Энэ Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлийг бүхэлд нь хянаж батлахгүй байгаа буюу өөрөөр хэлбэл орон нутаг, нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг хянан батлахгүй байгаа бас явдал байна. Өөрөөр хэлбэл бид нар нэгдсэнээр баталдаг мөртөө улсын төсвийн гүйцэтгэлийг л сонсдог. Тэгэхээр үүнийг Улсын Их Хурал нэгэнт нэгдсэнээр бид нар Улсын Их Хурал баталж байгаа бол нэгдсэн байдлаар гүйцэтгэлийг сонсох нь зүйтэй юм байна гэж Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд зохих өөрчлөлтийг орууллаа.

Мөн Засгийн газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөгөөний төсөл, төслийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг тодорхой хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлдэг, Улсын Их Хуралд танилцуулах эрх зүйн зохицуулалтуудыг бид бас илүү сайн бий болгож өглөө. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол хуульд заасан дүгнэлтээ гаргаж, хяналт тавих Улсын Их Хуралд танилцуулах, гишүүдийг мэдээллээр хангах, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй. Одоо бол яадаг вэ гэхээр Улсын Их Хуралд өгөөд, Улсын Их Хурал цаашаагаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлдөө өгнө гэсэн байдлаар ингээд орхигдоод байдаг. Гэтэл Үндэсний аудиттай адилхан эртхэн шиг аваад, дүгнэлтээ гаргаад Улсын Их Хурал дээр холбогдох Байнгын хороод дээр нь Үндэсний аудитын газартай адилхан зэрэгцээд тайлан мэдээллүүд, дүгнэлтүүдээ танилцуулдаг байхын тулд бас энийг өглөө.

Мөн сая өнгөрсөн намрын чуулганаар бид гол анзаарсан зүйл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбоотойгоор төсөв хэлэлцэн батлах хугацаа, чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна гэдэг бол анзаарагдсан. Ингэснээр

хоригийг хүлээн авснаас шалтгаалан төсвийг шинээр хэлэлцэх асуудалд хууль зүйн маргаан үүсэхгүй байх дэгийн хувьд эрх зүйн орчныг тодорхой болгож, бүхэлд нь хэрвээ Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хориг тавих юм бол Улсын Их Хурал хүлээж авах шийдвэр гаргавал Засгийн газарт буцаадаг. Хэрвээ хэсэгчлэн хориг тавих юм бол хоригийг холбогдох Байнгын хороо буюу Төсвийн байнгын хороо Засгийн газар луу буцаах уу, эсвэл төсөв дээр Улсын Их Хурлаас ажлын хэсэг гараад ажиллах уу гэдэг дээр Төсвийн байнгын хороо, Мэргэжлийн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганд дүгнэлтийг танилцуулахаар орууллаа. Төсвийн хоригийг хүлээж авах хэсэгтэй нь зэрэгцүүлнэ.

Ийнхүү Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж өргөн барьсан. Энэ хууль бол Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Ариунзаяа нарын өргөн барьсан хуулийн төслүүдтэй хамтдаа Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх учраас Төсвийн байнгын хорооны гишүүддээ цаглавартай холбоотой 2 хуульд ямар өөрчлөлт оруулах санал, дүгнэлт манай Байнгын хорооноос гарсныг танилцуулж байна.

Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсөвт үзүүлж байгаа хууль тогтоомжуудын ачааллыг бууруулахтай холбоотой бид нар зардлыг 4 салбарт хуваан авч үзсэн байж байгаа.

Нийгмийн салбарын төсөвтэй холбоотойгоор гэхэд хүчин төгөлдөр мөрдөж байгаа салбарын зарим хуулиудад туссан тусгайлан олгох санхүүжилттэй холбоотой заалтууд нь улсын төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, тэмцэлд нөлөөлж, Төсвийн тухай хуулиар хэрэгжих ёстой нэгдсэн бодлого алдагдах нөхцөл бий болж байна. Хэд хэдэн хуулиудаар шууд төсвийнхөө тэдэн хувийг, ДНБ-ий тэдэн хувийг заавал үүнд зарах ёстой гэсэн ийм хуулийн зохицуулалтуудыг хийгээд өгчихсөн. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ бол эдийн засгийн хүнд цаг үед ч гэсэн ямар нэгэн зохицуулалт хийхэд их амаргүй болж эхэлж байна. Ийм хуулиуд бол сүүлийн үед Улсын Их Хурлаар нэлээдгүй батлагдаж байгаа.

Иймд салбарын хуулиудаар төсвийн тэнцэлд нөлөөлөх зохицуулалтуудыг тусгасныг Төсвийн тухай хуульд нэгтгэн зохицуулах замаар төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, төсвийн сахилга бат, уялдаа холбоог хангах эрх зүйн орчныг бид бүрдүүлэх ёстой. Өмнө нь бол бид бас Валютын сангийн хөтөлбөрт орж байхад ялангуяа төсвийн бодлого бол нэгдсэн байх ёстой шүү. Олон хуулиудаар ингэж хэтэрхий замбараагүй болгодог нь төсөв сүүлдээ хяналтаа алддаг гэдэгт бид нарт бас зөвлөмж өгч байсан.

Мөн нийгмийн салбарт хуваарилагдаж байгаа төсвийн хэмжээ бол тасралтгүй өсөж байна. 2025 онд 16,1 их наяд төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн 48,2 хувь, нийт урсгал зардлын 63,6 хувийг эзэлж байгаа. Энэ нь бол төсвийн тогтвортой байдал, зардлын үр ашигт бас сөргөөр нөлөөлж байна. Халамжийн зардал гэхэд 2025 онд нийтдээ 2,9 их наяд төгрөг. Энэ бол нэгдсэн төсвийн 8,6 хувь. Төсөвлөснөөс 2,1 их наяд төгрөг бол бэлэн мөнгөн тэтгэмжид зориулагдаж байгаа. Энэ бол хүүхдийн мөнгө бас орж байгаа гэсэн үг. Иймд нийгмийн салбарын төсвийн бүтцэд шинжилгээ хийж, 20 хүртэл хувиар бууруулах замаар зорилтот бүлэгт илүү их чиглэсэн үр дүнтэй оновчтой төсвийн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэхийн тулд ялангуяа зорилтот бүлгийг тодорхойлоход цахим бүртгэл, иргэдийн бүртгэл бол маш чухал байгаад байгаа юм. Хүний оролцоо энд ороод л эхлэх юм бол ямар нэгэн байдлаар алдаа, дутагдал гарах магадлалтай байдаг учраас

ялангуяа цахим яамтай болсон, цахим бүртгэл сайжирснаар бараг цахимаар үүнийг аль өрх халамжид хамрагдах боломжтой вэ гэдгийг нь хүртэл шийдэх ийм шийдлүүд бас байж болох юм. Сүүлийн 10 жилийн хугацаанд нийгмийн салбарын төсөв бол огцом өссөн хэдий ч санхүүжилт нь ихэвчлэн гүйцэтгэлд тулгуурлаж, бодит үр дүн, чанарт суурилсан хуваарилалт бол хангалттай бол биш харагдаж байна. Нийгмийн салбарт ч гэсэн иргэдийн бухимдал бол маш их байгаа. Тэгээд энэ бол түүний нэг илрэл болж байна. Үүний улмаас зарим тохиолдолд үр ашиггүй зардал, давхардсан санхүүжилт, бодлогоос гадуур чиглэлд хөрөнгө зарцуулах эрсдэл бол нэмэгдэж байна.

Мөн үүнээс гадна, ялангуяа яг иргэд рүү чиглэсэн зардлаас илүүтэйгээр бүтцийн зардалд маш их төсөв санхүүжилт тавигдаж байна. Тухайлбал ДНБ-ий 2 хүртэлх хувийг шинжлэх ухааны арга хэмжээнд зарцуулах санхүүжилт 2015 онд 457,9 тэрбум төгрөг байсан. 2025 онд 2 их наяд болж, 4 дахин нэмэгдсэн. СӨБ, ЕБС, МСҮТ-ийн нэг суралцагчид олгох хувьсах зардал 2015 онд нийтдээ 747,6 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 2,8 их наяд буюу 3,7 дахин, МСҮТ-ийн дотуур байр, хоол ундны зардал орон нутгийн өмчийн ЕБС-ийн дотуур байрны хувьсах зардал бол 2015 онд 9,2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 116,9 тэрбум төгрөг болж, 12,7 дахин нэмэгдсэн. Энэ хугацаанд бол төсөв 4,5 дахин сүүлийн 10 жилийн хугацаанд нэмэгдсэн байхад зарим зардлууд бол 12,7 дахин нэмэгдсэн харагдаж байна.

Мөн ЕБС-ийн үдийн хоолны зардал 2015 онд 21,6 тэрбум төгрөг, 2025 онд 150,1 тэрбум төгрөг болж 6,9 дахин өссөн байна. Иймд нийгмийн салбарын үр дүнг суурилсан санхүүжилтийг бид үр дүнд суурилсан санхүүжилт рүү бүрэн шилжүүлэх хэрэгцээ шаардлага бол байна гэж үзэж байна. Мэдээж хүн амын өсөлт, хүүхдийн эрүүл ахуйтай холбоотойгоор зардал нэмэгдэх бол ойлгомжтой. Тэгэхдээ үүнийг илүү үр ашигтай, үр дүнтэй зарцуулахад илүү сайн дүн шинжилгээ хийх шаардлагатай байна гэж үзэж байна. Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн баталгаа орон тоотой холбоотойгоор одоогийн байдлаар төрийн албан хаагч төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн удирдлага, ажиллагсад, гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн ажиллагсад гээд энэ хүрээнд олгож байгаа цалин нийгмийн баталгаа бол салангид зохицуулагдаж байгаа. Зарим төрлийн цалин, урамшуулал, нэмэгдэл нь харилцан уялдаагүй, хэт төвлөрсөн байх нь төсвийн зардал, төрийн албаны бүтээмж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байгаа нь төрийн албаны цалин нийгмийн баталгааны тогтолцоог ер нь уялдуулах, цалин урамшуулал, нийгмийн баталгааг нэгтгэх зорилгоор төрийн албаны цалин, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Одоо бол төрийн албаны тухай хуулиар бол магадгүй илүү их гол зарчмууд, ахин дэвших мерит гэх мэт эдгээр нь байгаад, харин яг цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотойг олон салбар хуулиудаар хийдэг биш нэгдсэн 1 хуультай болох нь яваандаа манай төрийн алба үүнтэй холбоотой цалин, нийгмийн баталгааны асуудалд илүү чухал юм.

Улсын дээд шүүх, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо, ХЭҮК гэх мэтчилэн жилийн төсвөө Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор шууд хянагдаж, улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүүгийн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлдэг байгууллагуудын төсөв бол сүүлийн

жилүүдэд бол огцом нэмэгдсэн. Зарим зардлууд 13,5 дахин, жишээлбэл сүүлийн 10 жилийн хугацаанд улсын төсөв бол 4,5 дахин нэмэгдсэн. Тэгэхэд зарим байгууллагын төсөв бол 13, 14, 15 дахин нэмэгдсэн ийм зардлууд бас байна. Яваандаа бас хэрвээ эдгээр байгууллагуудын Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын хувьд эдгээр зардлуудыг байгууллага хянуулахгүйгээр төсвийн төсөлд нэгтгүүлдэг байгаад бас дүгнэлт хийх. Ингэнэ гэх юм бол энэ төсвийн зарлагатай холбоотой үр дүн, үр ашгийг бас хянадаг байх зохицуулалтууд хэрэгтэй байна.

Бүх салбарын төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгодог 1 удаагийн тэтгэмжийг Төрийн албаны тухай хуулийн хүрээнд үндсэн цалингаас төрийн албанд ажилласан хугацааг нь үндэслэн тооцдог байх. Зарим нь яадаг вэ гэхээр үндсэн цалингаасаа, зарим салбарынх болохоор үндсэн цалин нэмэх нь нэмэгдлүүдээрээ тооцоод байгаа юм. Зарим нь болохоороо 1 удаагийн тэтгэмж бол илүү бас ялгаатай байгаад байгаа. 36 сараас. Тэгэхээр энэ бол бас төрийн албан хаагчдын дунд хоорондоо гомдол үүсдэг бас нэг асуудал болдог. Тэтгэвэр тогтоолгохыг Нийгмийн даатгалын нэгдсэн хуулиар хийх хэрэгтэй байна. Зарим хуулиуд дээр бол салбарын хуулиудаараа тэтгэврийг тогтоодог асуудлууд бол байдаг. 2023 онд Нийгмийн даатгалын багц хуулийг батлахдаа үүнийг бол нэлээдгүй цэгцэлсэн. Салбар салбарын хуулиудаар байдгийг нэлээдгүй цэгцэлсэн. Гэхдээ үүнийг бас үргэлжлүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа. Одоо мөрдөгдөж байгаа тогтолцоо нь олон төрлийн давхардсан тэтгэмж олгож байгаа. Төсвийн зардлыг бас энэ нэмэгдүүлж байна. Тухайлбал мэргэжлийн боловсролын сургуулийн багшид 5 жил тутамд 1 удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог. Үүнд бол жишээлбэл, 2025 онд 2,3 их наяд орчим төгрөг төсөвлөгдсөн байна. Харин дээрх сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, арга зүйч, номын сан, эмч, тогооч гэх мэтчилэн зарим албан тушаалтнуудад бол эхний 5 дахь жил болон дараагийн 3 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж олгоно гэж байгаа юм. Энэ бол 2015 онд 4,8 тэрбум төгрөг, 2025 онд 78,1 тэрбум төгрөг болж бас ялгаатай тогтоогдож байгаад бид бас анхаарах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл орон нутагт нэгэнт л бид төрийн албан хаагчдыг ажиллуулахад орон нутаг төрийн үйлчилгээ бол сайн олгогдох ёстой. Бид нар чанар хүртээмжид нь анхаарах ёстой гэж байгаа бол энэ илүү их нэгдсэн зохицуулалттай бас явах хэрэгцээ шаардлага байна. Эдгээр урамшууллын хуваарилалт нь бол үр дүнд суурилсан бус, тогтмол хугацааны шалгуураар олгогдож байгаагаас гадна салбар салбараасаа заримдаа салбарын хууль дээр тусгагдсанаасаа шалтгаалаад ялгаатай байна.

Төрийн албаны тухай хуулийн төрийн албаны ангиллыг ер нь өнгөрсөн хугацаанд бол нэлээдгүй сайжруулсан. Маш олон ангилал, зэрэглэлтэй, 100 гаруй 130 орчим ангилал зэрэглэлтэй байсныг нэлээн чамбайруулж 50, 60 орчим болгож сайжруулсан. Гэхдээ үүнийг цаашид бас улам сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа юм.

Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ажлын нөхцөл суурьшлаас хамааран олгогдож байгаа тэтгэмж, урамшуулал, хэмжээ, давтамж, аргачлал бас харилцан адилгүй байгаад байна. Бас үүнээс үүдээд төрийн албан хаагчдын хооронд 1 салбараас нөгөө салбар луу орон нутаг шилжих, дээрээс нь нэмээд шударга бус байна. Өөрөөр хэлбэл нөгөө талдаа Хөдөлмөрийн тухай хуулийн олон улсын хөдөлмөрийн байгууллагад бид нар элсэн

оролцсонтой холбоотойгоор ижил тэгш хөдөлмөрт ижил үнэлэх ёстой гэсэн энэ зарчим бас алдагдаж байна гэдэг нэлээдгүй шүүмжлэл байна. Тийм учраас орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн албан хаагчдад олгож байгаа тэтгэмж урамшууллын нэгдсэн бодлого бид нар хэрэгтэй байна.

Эдийн засаг, дэд бүтцийн төсөвтэй холбоотойгоор бол хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгож байгаа татаас урамшууллын эдийн засаг, нийгэмд үзүүлж байгаа үр нөлөөг тодорхойлсны үндсэн дээр үр дүн, үр ашиг муутай, түүнчлэн хуулиар зохицуулаагүй татаас урамшууллыг бид нар дахин харж авч үзэх, заримыг нь бол зогсоох шаардлагатай байна гэж үзэж байна. Зарим жишээлбэл бид нар ялангуяа уналтад орчихсон үед үүнийг дэмжих аж ахуйн нэгжүүдийг ялангуяа эхний шатанд үйл ажиллагааг нь дэмжихэд салбаруудад бол улс орнууд бол ийм дэмжлэгүүдийг бол үзүүлдэг. Ингээд 5-10 жил байдаг юм уу, 15 жил явсны дараа тухайн салбар нэлээн сайн тогтворжсоны дараагаар урамшууллуудыг нь бууруулаад, илүү их зах зээлийн жишиг рүү оруулдаг байтал манайх бол тасралтгүй олгож явсаар ирсэн. Үүний үр дүнд бол зарим салбарууд бол төрөөс хэт их хамааралтай болдог. Яг зах зээлийн зарчим руугаа шилжиж чадахгүй байгаа нь бас харагдаж байгаа.

Мөн анх хэрэгжүүлж эхэлсэн үеийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлж байгаа үр нөлөөг нь иж бүрэн байдлаар үндэсний үндсэн дээр бид нар дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг Улсын Их Хурал тогтоомжоор баталгаажуулсны үндсэн дээр төсөвт тусгах бүр хэрэгцээ шаардлага бол байна. Сүүлийн үед бол ялангуяа Улсын Их Хурлын тогтоолоор төсөвт байхгүй маш их зардлуудыг төсөв дээр янз янзын урамшууллуудыг маш их тогтоодог болсон. Тэгээд үүн дээр бас бид бас зайлшгүй анхаарах хэрэгтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр тус бүрд хэрэгжилтийн хугацаа, зорилтот үзүүлэлт, хариуцсан байгууллагын тодорхой тусгадаг, үр ашигтай багатай байх юм бол үүн дээр арга хэмжээ авдаг хяналт шинжилгээ хийх аргачлал зохицуулалтыг салбарт бол бий болох хэрэгтэй байна. Төсвийн жилд санхүүжүүлэх хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг буцаад Улсын Их Хуралд бас тайлагнадаг, үр дүнг нь хангаагүй тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалтуудыг төсвийн тухай хуульд ер нь ганц энэ салбарт төдийгүй бас бусдад нь ч гэсэн тусгаж өгөх хэрэгтэй байна. Сая бол 2024 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байхад манай Улсын Их Хурлын гишүүдээс энэ асуудлыг бол маш их ярьсан. Ингээд малын вакцин, мал эмнэлгийн үйлчилгээний зардлын тодорхой хувийг шат дараалалтайгаар малчин өөрөө төлөх тогтолцоог бүрдүүлэх гэх мэтчилэн, мөн авто зам ашигласны төлбөр хураамжийг замын засвар арчилгааны хэрэгцээ шаардлагатай уялдуулж уян хатан тогтоох. Энэ бол улсын төсвөөс тавьж өгөөд байгаа. 2024 онд гэхэд нийтдээ зам арчилгаатай холбоотой нийт зардал бараг 400 орчим тэрбум төгрөг болж нэмэгдсэн байна лээ. Тэгэхээр энэ бүгдийг улам сайжруулах хэрэгтэй байна.

Авто зам арчлал, урсгал засварын хариуцагч ТӨК-удын засаглалыг сайжруулах, зарцуулалтыг ил тод болгох хэрэгтэй байна. Авто замын сангийн авто зам арчлалд урсгал засвар гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг санхүүжүүлэхэд 2015 онд 33 орчим тэрбум төгрөг байсан бол 2025 онд 120,9 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

Гадаад зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гэх юм бол төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтөөс эхлээд хэрэгжилт, хяналт, тайлагналт, үнэлгээ хүртэлх төслийн бүх үе шатад хамаарах энэ харилцааг зохицуулах, төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой Төсвийн хөрөнгө оруулалт удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь Засгийн газраас зүйтэй гэж үзэж байна. Сангийн яам бол үүн дээрээ бас нэлээн ажиллачихсан юм байна лээ. Тэгэхээр энэ бол Төсвийн тухай хууль дээр явж байгаагаас илүүтэйгээр энэ бол нэлээн их процессын хууль учраас тусгайлсан хуультай байх нь зүйтэй.

Аймгуудын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг байх. Орон нутгийн удирдлагатай хийх гэрээнд үр дүн тусгагдах байх. Хариуцлагатай уялдуулах эрх зүйн орчныг бид нар бий болгох шаардлагатай байна. Зарим аймгууд бол өнгөрсөн парламентад бид нар төсвийн өнгөрсөн 15 жилийн дүн шинжилгээ хийхэд зарим аймгууд бол 15 жил төсвийн хөрөнгө оруулалт маш муу байна. Тэр аймгийн 1 хүн амтай тооцсон хэрэгцээ шаардлага, ядуурал, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг үл харгалзан Улсын Их Хурлын гишүүд нь энд хөөцөлдлөгөө сайтай байх юм бол хөрөнгө оруулалт гайгүй татдаг. Муу байх юм бол хөрөнгө оруулалт муу байдаг ийм үзүүлэлт бол байж болохгүй. Үүний үр дүнд жишээлбэл баруун аймгаас гэхэд Говь-Алтай аймаг хамгийн муу хөрөнгө оруулалттай. Баруун аймгаасаа ядуурлын түвшин хамгийн өндөр. Зүүн аймгаас гэхэд Дорнод аймаг улсын төсвийн хөрөнгө оруулалт хамгийн муу. Үүнийгээ дагаад ядуурлын түвшин хамгийн өндөр. Ингээд говийн бүсээс гэж байхад Говьсүмбэр аймаг, Дундговь аймаг 2 ер нь бол улсын төсвийн хөрөнгө оруулалт хамгийн муу. 15 жил тасралтгүй хамгийн муу байсан аймгуудын 1. Ядуурлын түвшнээрээ говийн бүс дотроо хамгийн өндөр байх жишээтэй. Тэгэхээр ийм аймгуудын хувьд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харж байж хөрөнгө оруулалтуудыг шийддэг байх. Мөн үүний үр дүнг аймгийн Засаг даргатай Ерөнхий сайдын байгуулдаг үр дүнгийн гэрээ дээр сайн тусгаж өгөх хэрэгтэй байна.

Төрийн аудитын байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл төсөвт өртгийн магадлалын дүгнэлт гаргаж байгаа ч энэ бол эрх зүйн тогтсон зохицуулалт байхгүй. Үндэсний Аудитын газар бол үүнийг хийх ёстой гэсэн Аудитын тухай хуульд энэ бол аудитын хийх ажил бол биш байгаад байгаа юм. Тэгэхээр магадлалын дүгнэлт гаргаснаас хэрэгжилт сул, үр өгөөжийг нь тодорхойлох боломжгүй төсөл арга хэмжээг дахин үнэлж, санхүүжилт олгох шийдвэрийг үндэслэлтэй гаргах хэрэг хэрэгтэй байна. Магадгүй зөвхөн төрийн буруутай үйлдлээс үүдээд тухайн төсөвт өртөг нь нэмэгдэх юм бол Даваасүрэн дарга, тэгэх юм төсөвт өртгийг нь нэмэгдүүлэх, тийм биш бол төсөвт өртгийг нь нэмэгдүүлдэггүй. Ингээд тендер зарлахад төсөвт өртгийг нь хүлээн зөвшөөрөөд тендерт ороод ялчхангуутаа төсөвт өртгөө нэмэгдүүлээд байдаг биш. Хэрвээ харин эсрэгээрээ төр хийх ёстой ажлаа хийгээгүй бол хохирлоо барагдуулж нэг бодлын төсөвт өртгөө нэмэгдүүлэх энэ зохицуулалтыг хийж өгмөөр байна.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгийг хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны зориулалтуудад нийцүүлэн үр ашигтай, оновчтой ашиглах, зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийг хэрэгжих хугацаанд нь хяналт тавин ажиллах, зээл ашиглалтыг нэмэгдүүлэх, хугацаа хэтрүүлсэн төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэх хариуцлага үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг гэрээнд тусгаж ажиллах зохицуулалтыг бол боловсронгуй болгох хэрэгтэй байна. Энэ хүрээнд бол манай ажлын хэсгийн Батболд гишүүнээр ахлуулсан гишүүд улсын төсвийн хөрөнгө

оруулалтуудаар зээл, тусламжийн хөрөнгө оруулалтуудаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээтэй танилцсан. Зээл, тусламжийн хөрөнгө, зээлийн төсөл санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хувьд бол 1 зовлонтой нь бид нар аль болохоор 2025 оны төсвийг жишээлбэл алдагдалгүй төсөв батална гэхээр хамгийн их санхүүжилт нь хасагдаад байгаа нь гадаадын зээл тусламжийн төслүүд байгаад байгаа юм. Тэгэхээр хэдийгээр зээлийн эх үүсвэр нь байгаа ч гэсэн ашиглаж чадахгүй, зардал нь шууд улсын төсөв дээр зардал орж тавигдаад алдагдал нэмэгдээд байна гээд ашиглаж чадахгүй бас ийм байдлыг эрх зүйн орчны хувьд бас харж үзэх ёстой гэсэн ийм дүгнэлтийг ажлын хэсгээс гаргалаа.

Тэгээд байнгын хорооны эрхэм гишүүддээ ажлын хэсгийн санал, дүгнэлт шийдвэрийн төслийг та бүгддээ танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Булгантуяа гишүүнд баярлалаа. Ямар ч асуух асуултгүй болтол сайхан дэлгэрэнгүй тайлбарлалаа. Асуух асуултын гишүүн байгаа юм уу. Байна. Бас үлдсэн байна. Нэрээ өгөөрэй. Маш сайн ажилласан байна. Ингээд Жавхлан сайдыг оруулчихъя. Ингээд Жавхлан гишүүнээр таслаад, Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Байнгын хорооныхоо гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр ажлын хэсэг гаргаад ажилласан мэдээллийг дөнгөж сая л сонсож байна л даа. Уг нь урьдчилаад сонсоод, мэдээлэлтэй байсан бол нэлээн дэлгэрэнгүй зүйл бас асууж ярилцмаар зүйлүүд байсан. Тэгээд сая л би авч байна.

1 дүгээрт нь энэ гол зарчмыг нь өнөөдрийн энэ ажлын хэсгийн оруулж ирж байсан зүйл дээр Даваасүрэн даргаас арай өөр л саналтай л байна л даа. Ерөнхийдөө урсгал шинж чанартай ийм л бодит байгаа зүйл дээр яг тодорхой тийм шийдэл гаргасан ийм дүгнэлт орж ирээгүй байна гэж би ингэж үзэж байна. Тэгэхээр энэ төсвийн тухай хууль, төсвийн тухай асуудал дээр эхлээд төлөвлөлтөөсөө эхлүүлээд бид нар бүр бодлогын түвшинд авч үзэх ёстой. 2000 оны эхээр энэ төсвийн норм норматив, зарлагынх нь норм нормативыг нь тодорхойлоод, тэр дээрээ үндэслэж төсөвлөж явдаг. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль гээд байсан. 2010 оноос хойш төсвийн тухай хууль гээд хөтөлбөр, үр дүнд суурилсан ийм төсвийн төлөвлөлтийн систем рүү бид нар орж эхэлсэн юм. Гэтэл өнөөдөр бид нар энэ төсвийг яг ямар үр дүнг авахын тулд боловсролын салбар, нийгмийн салбар дээр хамгийн өндөр төсөв өгч байна гээд байдаг. Яг боловсролын салбар дээр тухайлсан цэцэрлэг дээр, тухайлсан эмнэлэг дээр ямар үр дүнд бид нар хүрэхийн тулд ямархуу хэмжээний төсөв мөнгө зарцуулаад байгаа юм бэ. Тэр үр дүндээ бид нар хүрч чадаж байна уу гэдэг дээр бид нар дүгнэлт өгөх ёстой юм. Тэр төсөвлөлт нь явж чадаж байна уу гэдэг дээр. Өнөөдөр төсвийн ерөнхийлөн захирагч нар тийм эрх мэдэлтэй байж чадахгүй байгаад байна шүү дээ. Төсвийн тухай хууль дээр хөтөлбөр үр дүнд суурилсан төсвийн чинь үндсэн гол зорилго нь бол энэ ерөнхийлөн захирагч нар буюу сайд нар, салбарын сайд нар чинь бодлогоо гаргаад, тэр бодлогоо хэрэгжүүлэхтэй холбоотой ийм үр дүнд хүрнэ. Ингэхийн тулд надад ийм төгрөг хэрэгтэй гэдгийгээ танилцуулж оруулж ирдэг шүү дээ. Гэтэл өнөөдөр төсвийн яг энэ анхны оруулж ирж байсан төсвийн тухай хуулийн шинэчлэл, бодлогын чинь үндсэн хэрэгжилт нь бодит байдал дээр нийцэхгүй байгаа. Энэ дээр ямар ч юм та нар оруулж ирээгүй байна шүү дээ. 1 дүгээрт.

2 дугаарт нь энэ юутай холбоотой асуудлууд нэлээдгүй олон асуудлууд байна л даа. Их Хурлыг бас 9 сарын 15-нд хуралдуулахтай холбоотой асуудал бас оруулж ирж байна. Одоогийн байгаа хуулиараа 10 сарын 1-ээс явахаар байгаа. Их Хурлын гишүүдийн эхлэх хугацаа нь, хуралдах хугацаа нь ингээд эхэлчихээр тойрог дээр яг сонгогчидтойгоо уулзах ажил чинь бас тасалдаад байна л даа. Одоо ингээд яг явъя гэж бодож байтал төсвийн тодотгол энээ тэрээ гээд цаг үеийн юмнууд орж ирэхээр ингээд бас ингээд явж чадахгүй, төсвийн энэ удаагийн хаврын чуулган нь 6 сарын 26-нд дуусах ёстой байтал ингээд дахиад наадам хүртэл үргэлжилж хуралдахаар бид нар болж байна.

Энэ зах зээлтэй холбоотой хөдөө аж ахуй салбар дээр холбоотой энэ зах зээл рүү шилжүүлэхтэй холбоотой асуудлууд .../минут дуусав/

Д.Батбаяр: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Бид бас ингэсэн. Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төсөл оруулъя гэсэн тогтоолын төсөл оруулж болохгүй байгаад байгаа юм байна. Зүгээр ажлын хэсгийн санал, дүгнэлтээ л танилцуулах ёстой болчихоод байгаа юм байна. Тэгэхээр яах вэ, үр дүн, төсөв 2-ыг уях талаар тодорхой юу байхгүй байна гэж байна. Энд бол уг нь бол хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд чиглэгдээд, бид нар чинь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаад, жил болгон жилийн төлөвлөгөөг нь батлаад, жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг нь сая бид нар 2025 оны 3 сард баталсан шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яамнаас орж ирээд. Түүний араас бид нар чинь төсвөө энэ үр дүнтэйгээ хэрхэн яаж уялдаж төсөв нь гарсан бэ гэдгийг төсвийн гүйцэтгэлийг сая л жишээлбэл бид нар хэлэлцсэн. Тэгэхээр яг л үүнтэй адилхан энэ 2-ын уялдаа бол уг нь хуучин бол тийм хуулиар явдаг байсан бол одоо Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон төсвийн гүйцэтгэл, төсөвтэй холбоотойгоороо л ингээд уягдаад явж байгаа.

Бидний хувьд харин өөрсдөө бас энүүхэндээ гэж хэлэхэд зарим тохиолдолд манай Улсын Их Хурал бид нар өөрсдөө заримдаа хариуцлагагүй байна гэж бодож байгаа. Яагаад гэвэл Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль дээр жишээлбэл сая жилийн төлөвлөгөөгөө боловсруулаад Засгийн газраас оруулж ирэхэд энд бид нар бараг 3 их наядаар зардлыг нь нэмсэн. Тийм хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөгжлийн жилийн төлөвлөгөөг нь нэмж баталж өгсөн. Тэгэнгүүт ирэх жил яах вэ гэхээр 3 их наяд орчим төгрөгийн нэмж зардал гаргах хөгжлийн төлөвлөгөөг нь бид нар батлаад өгчихөөр улсын төсвийг нь тэгж тавьж чадахгүй шүү дээ. Тэр тусмаа эдийн засаг хүнд байгаа үед. Тэгсэн мөртөө төсвийн хүрээг нь тэгвэл Засгийн газраас оруулж ирснээс нь 3 их наядаар бид нар нэмж тавьж өгөх ёстой шүү дээ. Тэгж байж дараа нь үр дүнгээ харахаар хөгжлийн бодлого төлөвлөлт дээр чинь төсөв мөнгө тавьж байгаа нь л төсөв. Уг нь бол хойд талд нь мөнгө тавьж байгаа юм. Тэгээд энэ 2-ын улдааг хангах ажлыг одоо бид нар Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад бас удаагүй байна. Хуучин бол Сангийн яамыг үүнийг хөгжлийн бодлого төлөвлөлтөө төдийлөн сайн хийж чадахгүй байна. Нягтлан бодох бүртгэл шиг л ажиллаад байна гэж шүүмжлээд бид нар Эдийн засаг, хөгжлийн яамтай болсон юм бол энэ 2-ын уялдааг уг нь бол илүү сайн Эдийн засаг, хөгжлийн яам маань ингээд гаргаад явах ёстой гэдэг ийм л чиглэлийг ажлын хэсгээс өгсөн юм. 9 сарын 15-тай холбоотой ингэсэн юм. 9 сарын 1-нд Улсын Их Хуралд төсвөө өргөн барьчихлаа. Ингээд 10 сарын 1 хүртэл хэрвээ Улсын Их Хурал хэлэлцэх ч үгүй, олон нийтийн хэлэлцүүлэг хийх ч үгүй, ямар ч хэрвээ ажиллагаа явуулахгүй юм бол 9 сарын 1-нд өргөн барьсны ямар ч хэрэг

гарахгүй байна. Үнэнийг хэлэхэд 9 сарын 1-нд өргөн барахын тулд бол 7, 8 сард бараг төрийн албан хаагчид ажиллаж байж энийг өргөн барьж байгаа. 8 сарын 15 гэхэд Засгийн газар дээр төсвөө бараг боочихсон байж байж өргөн барьж байгаа. Гэтэл 10 сарын 1 хүртэл бид нар 9 сарын 15-нд 1 дүгээр хэлэлцүүлэг яваад, тэр дээр 2 хоног байдаг юм уу Ерөнхий сайд танилцуулгаа хийгээд, бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар суугаад, Улсын Их Хурлын гишүүд асуултаа асуучхаад, дараа нь 27 хоног хэртэй тойрог руугаа яваад, салбарын хэлэлцүүлгүүдээ хийгээд 10 сарын 1-нд илүү их олон нийтийн .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Булгантуяа дарга аа, тэгэхдээ таны саяын ярьж байгаа юмнууд чинь ингээд л бид нар энэ юмыг чинь яриад 10, 20 жил явж ирлээ шүү дээ. Бид нарт шинэчлэл хэрэгтэй байна шүү дээ. Төсвийн томоор нь бид нар хармаар байна шүү дээ. Тэгээд л ингээд л уламжлалт ярьдаг юмаа яриад, ингээд л нэгэндээ ээлжлээд л ингээд бөөрөнхий ерөнхий юм яриад яваад байдаг. Ийм юм баймааргүй байна аа. Хөтөлбөр, үр дүнд суурилсан төсвийн бодлого чинь алдагдчихсан. Бүх юм чинь Сангийн яам дээр төвлөрчихсөн. Сангийн сайд гэж үндсэндээ Монгол Улсын 2 дахь Ерөнхий сайдын хэмжээний ийм албан тушаал болчихоод явж байна шүү дээ. Гэтэл та төсвийнхөө хуулийнхаа энэ шинэчлэлийг аваад үз л дээ. 2011 онд батлагдсан Төсвийн тухай хуулиа аваад 2001 онд батлагдсан тэр төрийн байгууллага, удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2-оо харьцуулаад үз л дээ. Яг энэ анх батлагдаж байсан тэр бодлогын үндсэн үзэл баримтлал энээ тэр нь бодит амьдрал дээр хэрэгжилт нь шал өөр болоод хувирчихсан явж байгаа шүү дээ. Үгүй ээ, тэгээд ажлын хэсэг гарч байгаа юм бол энэ дээрээ том дүгнэлт өгмөөр байна шүү дээ.

Аудитын байгууллага гээд ярьж байна. Аудитын байгууллага нэг дүгнэлт гаргадаг, дүгнэлтийг нь авч үзэхгүй байна. Энийгээ сайжруул гэсэн юм орж ирж байгаа юм. Гэтэл олон улсад аудитын байгууллагын чинь 3 үндсэн тогтолцоо явж байна шүү дээ. Аудитын байгууллага нь дэргэдээ шүүхтэй. Асуудал гарвал шууд шүүхээрээ шийдээд, шууд биелүүлээд явах ийм шаардлагатай явж байна. Аудитын байгууллага нь зөвлөлтэй явж байна. Ерөнхий аудиторовн тогтолцоо явж байна. Өнөөдөр манай Ерөнхий аудиторовн тогтолцоо 30 жил явлаа. Ингээд л бас энэ Засгийн газрыг илсэн ийм л хэлбэрээр явж ирсэн шүү дээ. Ийм томоохон хэмжээний шинэчлэлүүдийг дүгнэлт дээрээ оруулж ирэх ёстой байтал ямар ч тийм юм алга байна шүү дээ.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгө байна. Ямар ч үр ашиггүй зарцуулагдаж байгаа. Өнөөдөр гадаадад хэрэгжиж байгаа энэ 100 н төслийг чинь дагаад 3, 4 мянган хүн байнгын ажиллагаатай ажлын байртай явж байгаа. Энэ хүмүүс төсөл нь удаан явах тусмаа төсвийн насжилт нь удах тусмаа энэ хүмүүс чинь ажлын байртай яваад байгаа. Гэтэл үр дүн нь хаана байгаад байгаа юм бэ. 3, 4 жилийн хугацаанд төлөвлөчихсөн үр дүндээ хүрдэггүй, хойшлоод яваад байдаг. Төлбөр төлөх хугацаа нь эхлээд яваад байдаг. Эцсийн дүндээ гадаад зээл, тусламж гэдэг бол татвар төлөгчдийн мөнгөөр эргээд төлж байгаа шүү дээ. Хаана байгаа юм бэ. Үр ашиг нь. Ийм томоохон шинэчлэлийг энэ ажлын хэсгээс орж ирэх ёстой гэж би харж байсан. Өнөөдөр юу ч алга.

Ц.Даваасүрэн: Санал хэлчихлээ. Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд бас ялгаа байхгүй. Энэ ажлын хэсгийн сураг сонсогдоод байсан. Тэгээд төсвийн хорооны гишүүний хувиараа, мөн Зарлагын хяналтын дэд хорооны даргынхаа хувиар бас тодорхой санал уг нь хэлэх байх гэж бодож байсан. Танилцуулга дээр бас оролцоод, яг энэ санал, дүгнэлтийг боловсруулах явцад нь бас өөрийнхөө саналыг оруулаад явна гэж ойлгож байсан боловч тэгээд болоогүй байна. Тэгээд яг энэ төсвийн хэлэлцэх төсвийн хүрээний мэдэгдэл, гүйцэтгэлийг хэлэлцэх яг энэ үйл ажиллагаатай холбоотойгоор Зарлагын хяналтын дэд хорооны үйл ажиллагаа ямархуу байдлаар оролцож байгаа гэсэн ийм дүгнэлт гаргасан юм байна уу. Та түрүүн цаглавартай холбоотойгоор дурдсан. Энэ хөгжлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төслийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхийг шууд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргэдэг. Аудитын байгууллагад шууд Улсын Их Хурлаар дамжуулж хүргэдэг энэ тогтолцоогоо шууд зэрэг зэрэг бүгдэд нь хүргэмээр байна гэсэн ийм дүгнэлтийг хэлж байна. Тэгээд энэ дунд Зарлагын хяналтын дэд хороог чухам оролцуулах боломж байгаагүй юу. Энэ дүгнэлтдээ энд шаардлагатай гэж та хэд үзээгүй юу. Зарлагын хяналтын дэд хороо маань саналаа танд бас хэлж байсан. Бид нар ингээд бас яг энэ гүйцэтгэл дээр дүгнэлтүүдээ бас гаргамаар байна. Хангалттай хугацаатай баймаар байна. Тэгэхгүй учраас ингээд цаглавартай холбоотойгоор ерөөсөө 3, 4 хоногийн хугацаа гарчхаад байна. Энэ жилдээ 1 жоохон ийм иксепшн гарч ирээд 7 хоногийн хугацаа гарсан учраас бид нар сая мэдээлэл авах ийм бололцоо гарсан. Тэгэхээр яг энэ цаглавар болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн санал танд байгаагүй юу гэдэг ийм асуулт байна.

Ц.Даваасүрэн: Асуулт, үг хамт явж байгаа. Хариулах уу. Булгантуяа гишүүний микрофон.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг бол ажлын хэсгийн гишүүдийнхээ хүрээнд л гол ажлуудыг хийлээ. Мэдээж Улсын Их Хурлын гишүүдээс ямар ч цаг үед ямар ч Байнгын хороон дээр, ямар ч ажлын хэсэг дээр оролцоод ажиллах бол бүрэн боломжтой. Саналаа хүргүүлэх. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны зохицуулалт бол яг хуучин шигээ ер нь бол байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зохицуулалтуудыг бид нар яагаад нэмж хийж өгөх шаардлагатай болсон бэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр зарим нэг заалтууд байгаа ч гэсэндээ энэ бол хэзээ тайлангаа мэдээллээ, төсвийн төслөө хүргүүлэх вэ, хүрээний мэдэгдлээ хүргүүлэх гэдэг тэр зохицуулалтууд нь хаягдчихсан байсан учраас үүнийг нь бид нар нэлээн тодорхой болгож бол хүргүүлсэн.

1 дүгээр хэлэлцүүлэг, 2 дугаар хэлэлцүүлэг энэ тэр бол дандаа илүү их танилцах шинж чанартай хэлэлцүүлгүүд байна. 3 дугаар хэлэлцүүлгээс авхуулаад л хуучин процессын 2 дугаар хэлэлцүүлэг шиг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хороо зарчмын саналуудаа гаргадаг тэр зохицуулалтууд бол бүгд бол хэвээрээ байгаа. Хууль бол өргөн баригдчихсан. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга хэрвээ үүнтэй холбоотойгоор хөндөгдсөн зүйл заалт дээр бол нэмэлт зарчмын санал гаргаад, зарим нэг зохицуулалтуудыг хийх бүрэн боломж бол байгаа. Бидний хувьд энэ ажлын хэсэг бол үнэнийг хэлэхэд Төсвийн тухай хууль шиг том хуулийг бид нар боловсруулж чадахгүй. Ер нь чадахгүй юмаа чадахгүйгээрээ л хэлсэн нь дээр. Улсын Их Хурлын гишүүд ганцаараа сууж байгаад Эрүүгийн хуулийг шинэчлэн бичнэ гэж байхгүй. Алдаа гаргавал энэ чинь аюултай байхгүй юу. Төсвийн тухай хууль гэдэг бол эндээс цалинжиж байгаа нийт

200 гаруй төрийн албан хаагчдын цалин, энд бүх Монгол Улсын суралцаж байгаа хүүхдүүдийн асуудал, нийгмийн хүүхдийн мөнгөнөөс авхуулаад энэ бүх шимтгэл, татвар бүх юмнууд эндээс хамааралтай байдаг учраас ялангуяа энэ органик салбарын том хуулиудад хувь гишүүд бол 1, 2 зүйл заалтууд өөрчлөх хэмжээний л зарим нэг өөрчлөлтүүдийг оруулдаг нэмэлт, өөрчлөлт оруулдаг болохоос биш Заяабал гишүүний хэлснээр Төсвийн тухай хуулийг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг манай хэдэн гишүүд нийлж байгаад ийм том хуулийг бичиж чадахгүй. Ер нь үеийн үед хамгийн том хуулиудыг Засгийн газар л өөрөө бичихгүй бол бид нарт тийм нарийн мэдээллүүд ч байхгүй. Тийм мундаг хуульчид ч байхгүй. Хуульч болгон Төсвийн тухай хуулийг мэдэхгүй. Хуульч болгон Эрүүгийн хуулийг мэдэхгүй, Иргэний хуулийг мэдэхгүйтэй яг адилхан алдаа гаргавал үр дагавар их өндөртэй учраас энд бол бид нар зардалд үзүүлж байгаа дүн шинжилгээнүүд дээр хуулийн төслүүд дээр зардал дээр дүн шинжилгээ хийх гэдэг ажлын даалгавар Улсын Их Хурлын даргаас батлагдахдаа ингэж батлагдсан учраас бид нар энэ хүрээндээ л ажилласан. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах цаг нь болсон уу гэвэл болсон. Үүнийг Үндэсний аудитын газраас ч гэсэн олон жилийн дүгнэлт дээрээ бол гаргаж байсан. Бид нар бол үнэнийг хэлэхэд Төсвийн тухай хууль дээр төдийгөөс өдий болтол нэмэлт, өөрчлөлтүүд оруулаад, аргалаад л яваад байгаа болохоос биш бол бараг Даваасүрэн даргын үед Сангийн яам дээр ашиглаж байсан шахам л зарим нэг зохицуулалтуудаар яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг бол .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Тэгээд ажлын хэсгийн зорилго, зорилт, дүгнэлттэй ерөнхийд нь энэ санал нэгдээд байгаа юм л даа. Булгантуяа гишүүн ээ. Тэгээд чуулганыг 9 сарын 15-аас эхлүүлнэ энэ тэр гэдэг дээр санал нэгдэх зүйтэй байх гэж бодоод байгаа юм. Тэгээд миний асуугаад байгаа нь болохоор энэ зарлагын хяналтын дэд хороо яг энэ төсвийн хүрээний мэдэгдэл, гүйцэтгэлийг хэлэлцэж явахад арай жоохон эрт цаглаврын хувьд эрт мэдээлэл албан ёсоор авах ийм шаардлага байна ажлын хэсэг дээр үзээгүй юу. Та өөрөө юу гэж бодож байна Та өөрөө маш туршлагатай, Дэд сайд хүртэл хийж явсан ийм хүн учраас би тэр үүднээс л асуугаад байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Хэлэлцүүлэг дээр, цаглавар дээр л нөгөө Зарлагын хяналтын дэд хорооны хугацаа бага байна гээд байгаа юм. Яах вэ, энэ чинь хуулийн төслийг нь өргөн барьчихсан байгаа юм байна лээ.

Д.Батбаяр: Тэгээд ахиад хуулийн төсөл дээр яг энэ үйл ажиллагаатай холбоотой, яг Зарлагын хяналтын дэд хороотой холбоотой, үйл ажиллагаатай холбоотой..../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хариулъя Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны зохицуулалт бол яг хэвээрээ байгаа. Төсөв хэлэлцэхтэй холбоотой ерөөсөө 1 үе шат нэмсэн. Сая бид нар 2025 оны төсөв дээр гишүүдийн гол бухимдсан зүйл нь бид нар эхний удаа Ерөнхий сайд танилцуулгаа хийгээд, төсвийн ерөнхийлөн захирагч нараас 2 хоног бид нар асуулт асуугаад л шууд хуульд нийцэж байна, хэлэлцэхийг дэмжье гэдэг шиг тийм санал хураалт явуулсан. Дараа нь бид нар сайн танилцсан чинь болохгүй зүйлүүд байхад буцаах бид нар эрх зүйн орчин байхгүй болчихсон

байсан. Тэгэхээр одоо бол бид нар1 үе шат нэмээд, эхний үе шатад танилцана. 2 хоног хэртэй байх болов уу. 100 гаруй гишүүд асуулт асуугаад, түүнийхээ дараагаар яг үнэнийг хэлэхэд тойрог дээр очиход хамгийн чухал ярих юм нь ирэх жил манай улс яаж хөгжих гэж байна, тэтгэвэр яаж нэмэгдэх гэж байна гэхэд ярианы сэдэв нь энэ төсөв болно гэсэн үг. Төсвийн төсөл. Үүнийгээ авч очоод, тойрог дээр уулзалтуудаа хийгээд, эрүүл мэндийн салбарынхан гээд эрүүл мэнд дээрээ яриагаа хийгээд, буцаж ирээд буцаж ирээд буцаж ирээд түүний дараа магадгүй намын бүлгүүд ч гэсэн хуралдах байх. Энэ төсөв бол .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Үгүй ээ. Харин миний бодлоор зүгээр 5 дахь гэж байсан дор бол харин зүгээр эхний хэлэлцүүлэг нь Байнгын хороод бүгдээрээ ярьж байгаад тэгээд эхний хэлэлцүүлэг хийдэг 1 ердийн хууль шиг болгочихсон нь дээр байсан байж магадгүй шүү. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийнхээ санал дүгнэлттэй танилцсан. Мэдээж энэ хүмүүс үзэж хараад тодорхой саналуудаа хөндсөн байна. Үүнийг бид хүндэтгэлтэй авч үзээд, төсвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалтдаа анхаарах ёстой байх гэж ингэж ойлгож байна.

2, 3 тодорхой санаа байгаа юм. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бид 9 сарын 1-нд яагаад төсөв өргөн барих болсон юм гэж. 10 сарын 1-нд төсөв өргөн баригдаад, тэгээд л бид хэд мэдээлэлгүй чуулган эхлээд, тэгээд л явдаг зарчим тийм байгаад байсан байхгүй юу. Тийм учраас 9 сарын 1-нд нь өргөн бариулчихъя. Аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөрөө тодорхой дүгнэлтүүдээ гаргуулъя. Тэр дээр 20 хоног байгаа билүү дээ. Би тэгж санаад байна. Цаглаврынхаа хувьд. Дээр нь энэ Их Хурал гэдэг чинь зөвхөн чуулганы цагт ажилладаг, бусдад нь амардаг байгууллага биш шүү дээ. Бид хөдөлмөрийн хууль гэдэг юм уу, Төрийн албаны хуулиараа л ажилладаг. Тийм учраас тэр 9 сарын 1-дээ Их Хурал ажиллаж байх ёстой. Заавал чуулган хэлбэрээр биш, бүх Байнгын хороод нь, бүх гишүүд нь материалаа аваад танилцаад, ёстой 10 сарын 1-нд чуулган эхлэхэд асуух асуулт бүх юм тодорхой болчихсон мэдээлэлтэй хүмүүс байх ёстой байхгүй юу. Энэ бэлтгэлийг хангуулж өгөх гэж зориуд 1 сараар нааш нь татаж, энэ төсвийг өргөн мэдүүлэхээр хуульчилж зохицуулж өгсөн юм. Тийм учраас би Их Хурлын чуулганыг 9 сарын 15-нд эхлүүлэе гэдэгтэй бол санал нийлэхгүй байгаа.

Харин зүгээр Дэгийн гэдэг юм уу, Их Хурлын хуульдаа зохицуулалт хийх замаар тэр сарын хугацаанд Их Хурал, Байнгын хороод гишүүд ямархуу байдлаар асуудал дээрээ ажиллах юм гэдэг юмаа л тодотгоод өгчих. Өөр юм байхгүй.

2 дахь зүйл ер нь бид бодмоор ч юм шиг л санаад байдаг юм. Татварын талаар гэдэг юм уу төсвийн талаар баримтлах дунд, урт хугацааны стратеги юмнуудаа батлах ёстой юм биш биз дээ. Үйл ажиллагааны татвар гэдэг юм чинь ер нь ямар түвшинтэй байж байгаад өгсөж явах юм уу, уруудаж явах юм уу. Энэ хөрөнгөтэй холбоотой юм чинь ямар байх юм. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэйгээ яаж уягдах юм гэдэг ч юм уу. Төсөв гэдэг юм чинь ер нь ямархуу байдлаар явах юм. Ямар үзүүлэлтүүдтэйгээ яаж уягдаж зөв явах юм бэ гэдэг юмаа зөв зохицуулж өгсөн ийм бодлогын баримт бичиг гаргах байх. Тэгээд тэр нь эрх зүйн зохицуулалтаараа хангагдаад үе шаттайгаар явах ийм үйл явц байхыг би үгүйсгэхгүй гэсэн ийм саналтай байна.

Дараагийн нэг зүйл энэ төсөвт дан дамаа энэ дотуур байрны хүүхдийн хоол ч гэдэг юм уу ийм юм дээр оролцоог хангамаар байгаа юм. Эцэг эхчүүдийн гэдэг юм уу тэр хамрагдагсдын оролцоог тодорхой хуваарь хангаж байж хяналт бүртгэл сайжирдаг байхгүй юу. Хүүхдийн хоол дээр өдөрт 50 цаас эцэг эхээс төлдөг байхад л тэр ирцийн бүртгэл үнэн болно. .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмээд өгчихье. Санал хэлж байна.

Ж.Батжаргал: Энийг 1 бодмоор гэж. Тэр Хөдөө аж ахуйн салбар дээр бид хэд жоохон ад үзээд л байгаа юм. Би ч бол жоохон заримдаа дургүй хүрээд л байгаа юм. Энэ хөдөөгийн асуудал ганц салбарын юм биш. Хүнс хэрэглэдэггүй хүн, хувцас өмсдөггүй хүн гэж байхгүй. Энийг чинь бэлддэг салбар чинь энэ байхгүй юу. Дэлхий нийтээр өнөөдөр урамшууллын гэдэг юм уу, дэмжлэгийн гэдэг юм уу тогтолцоотой явж байгаа. Харин энэ дээр нь дүн шинжилгээ хийгээд яг юун дээр нь урамшуулал өгөх вэ, яаж зөв болгох вэ гэдэг л асуудал бий. Үүнийг бол бид харах ёстой, бодох ёстой зүйлүүд байгаа байх гэж би ойлгоод яваад байдаг. Дараагийн нэг зүйл энэ татварын ачаалал бууруулна, хөнгөлнө гэхээр орон нутгийнхаа эдийн засгийн чадамж төсвийн чадамжийг бууруулаад болж өгөхгүй байгаа юм. Татварын хөнгөлөлт эдлүүлээд л явчихаар зэрэг дандаа орон нутгийн төсөвт ордог орлогуудыг бууруулчихаад байгаа байхгүй юу. Энэ нь эргээд орон нутгийн өрсөлдөх чадварыг бууруулаад байгаа нэг ийм .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Санал хэлсэн учраас Ганбаатар гишүүн. Санал дээр тайлбар авах юм уу. Уг нь тийм юм байхгүй л дээ.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүнтэй бол санал нэг. Ерөөсөө олон улсын байгууллагуудаас ч гэсэн Монголд өгч байгаа зөвлөмжүүд нь мэдээж хүн амын өсөлт хөгжилтэй холбоотой нийгмийн хамгааллын хөгжлийн зардлууд гаралгүй яах вэ. Тэгэхдээ түүнийг үр дүнтэй уямаар байна. Хамгийн гол нь үр дүнтэй уямаар байна. Бэлэн мөнгөөр зүгээр өгчихдөг биш, иргэдийн оролцоо, эцэг эхийн оролцоо ч гэсэндээ чухал гээд энэ дээр Боловсролын хууль дээр Энх-Амгалан сайд бас өөрчлөлт оруулаад эцэг эхийн ч гэсэн оролцоог хангах зохицуулалтуудыг хийж өгсөн. Хамгийн гол нь нийгмийн зардал нэмэгдээд байхад энэ нийгмийн суурь үзүүлэлтүүд, асуудал сайжрахгүй байгаад бид өөрсдөө бас дүгнэлт хийх хэрэгтэй. Жишээлбэл, ингэсэн байна гишүүд ээ. Сүүлийн 20 жилд дотоодын нийт бүтээгдэхүүн бол 14,3 дахин, номинал дүнгээрээ 1 хүнд ноогдох нь 10,3 дахин нэмэгдсэн ч гэсэндээ ажилгүйдлийн түвшин 2008 оноос тооцоод аваад үзэхэд ажилгүйдлийн түвшин бол 2,5 дахин нэмэгдээд, ядуурлын түвшин 7,4 хувиар л буурсан байна. Тэгээд энэ хугацаанд бол 20 жилд хүн ам 1 саяар, хөдөлмөрийн насны хүн ам 800 мянга орчмоор нэмэгдсэн байхад ажиллагсдын тоо 400 мянгаар л нэмэгдсэн байна. Тэгэхээр энэ юуг харуулж байна вэ гэхээр бид нар төсөв маань тэлээд л байдаг, нийгмийн олон зардлууд маань нэмэгдээд л байдаг тэгсэн мөртөө яг байгаа онохгүй байгаа нь бол үнэн. Байгаа онохгүй байгаа нь бол үнэн. Боловсролын ч байдаг юм уу, эрүүл мэндийн ч байдаг юм уу, нийгмийн хамгааллын ч байдаг юм уу зардлууд байгаа онохгүй байгаад байгаа нь бол үнэн. Тэгэхдээ үүнийг бол Заяабал гишүүн ээ, манай энэ ажлын хэсэг дээр бид нар Төсвийн хуулийг ч байдаг юм уу, Халамжийн хуулийг барьж аваад 26 гишүүн сууж байгаад хийж чадахгүй. Энэ том органик хуулиудыг бол холбогдох яам, Тамгын газар нь өөрсдөө хийсэн нь дээр. Энийг бол Үндэсний аудитын газраас тайлан дээр нь тавьж байсан шүү дээ. Асуудлууд нь байна шүү дээ бас ийм юунууд байгаад байгаа юм. Та зээл, тусламжийн төслүүд хүртэл ер нь Монгол Улсад

хэрэггүй л гэнэ. Таныг Татварын дарга байхад татвар дээр хүртэл л хэрэгжиж л байсан шүү дээ. Бодвол хэрэгтэй л байсан байлгүй дээ тэр үед.

Бидний хувьд бас нэг ийм юм яриад байгаа юм. Хөдөө аж ахуйн салбарыг бид нар дэмжих дээр бол санал нэг байна. Гол нь үр дүнг нь хэмжээч ээ. Зарим нь бол ингээд үр дүнгүй байгаад байхад үргэлжлүүлэн өгөөд байгаа. Дээрээс нь нэмээд ялангуяа мал аж ахуйн салбар “Атрын 3” дугаар аянаас эхлээд Хөдөө аж ахуйн салбарыг сэргээхэд хүчтэй дэмжлэг үзүүлээд тодорхой хэмжээний сэргэсний дараагаар дэмжлэг нь арай багасаж явдаг олон улсын жишиг рүү шилжиж чадахгүй байна. Ингээд үргэлжлүүлэн энэ салбар ийм байгаад байна гэдэг дээр дүн шинжилгээ хийгээч. Зарим урамшууллууд, дэмжлэгүүд, тэр татааснууд гэдэг бол жишээлбэл хууль дээр суугаагүй байхад бүр энэ дуусах хугацаа ч байхгүй байна гэж байгаа юм. Хууль дээр суугаагүй мөртөө дуусах хугацаагүй, тасралтгүй хэрэгждэг. Тэгээд бид нар бүр ерөөсөө л энийг хэрэгжүүлэх ёстой гээд бодчихсон. Тэгэхээр үүний үнэлэлт, дүгнэлтийг өгөөч ээ. Энэ бол бас бага мөнгө биш. Жишээлбэл энэ арьс, сарлагийн .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тодруулах уу. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр бид энэ орон нутгуудыг өрсөлдөх чадварын үзүүлэлт гаргаад байгаа юм. Өрсөлдөх чадварыг нь үнэхээрийн нэмэгдүүлж байж энэ иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлье гэвэл сул байгаа тэр үзүүлэлтүүдийг нь дэмжсэн төрийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлого явах ёстой юм. Тэгж байж энэ сайжрах ёстой байхгүй юу. Тэрнээс биш зүгээр аймгийн нутаг дээгүүр дамжаад өнгөрч байгаа үндэсний хэмжээний том бүтээн байгуулалтын зардлыг Төв аймаг гэсэн нэрээр нь Төв аймгийн хөрөнгө оруулалт дээр тавьчихаад улсын хэмжээний хамгийн том хөрөнгө оруулалттай аймаг гээд яриад байж болохгүй байхгүй юу. Тэгэхээр үүнийг бид салгаж үзмээр байна.

Дараагийн миний нэг ганцхан хэлчихмээр байгаа зүйл байгаа юм. Төсвийн зардлыг хэлэлцэх цаглавар, горимыг харин ёстой төсвийн хуульд их тодорхой болгож оруулж өгч байж л бид энэ төсөв дээр жоохон гайгүй үр дүн, юмаа харж дараагийнхаа юмыг тодорхойлж чаддаг тийм баримжаатай болох ёстой. Өнөөдөр бид зүгээр л юм батлаад байгаа болохоос гүйцэтгэлээ хянаж чадахгүй байгаад байна шүү дээ. Энэ л аюул байгаа.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хугацаа дууссан. Ер нь бол яах вэ, салбарын хуулиуд дээр гишүүд боломжгүй биш юм. Боломжтой. Яагаад гэвэл та нарт мөнгө тавьж өгсөн байгаа шүү дээ. Хууль санаачлахад чинь зориулаад мэргэжлийн хүн хөлсөлж авч болно, хуульч хөлсөлж авч болно, мэргэжлийн хуулийн фирм хөлсөлж авч болно. Тийм учраас гишүүдэд хууль санаачлах, тэрийгээ хэрэгжүүлэх эрх байгаа бөгөөд санхүүгийн хувьд боломж байгаа гэж бодож байна. Г.Ганбаатар гишүүн байхгүй байна. Ж.Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Ганбаатар: Баярлалаа. 1 дүгээрт би олон зүйл дээр Заяабал гишүүнтэй санал нэг байна гэдгийг хэлье.

2 дугаарт би тэр 9 сарын 15 гэдэг дээр бид нар олон төсөв баталлаа шүү дээ. Булгаа бид 2 2016 оноос хойш л хамт суулаа. Тэгээд энэ төсвүүд чинь их сайн сайн төсвүүд батлаад, сайн сайн жилүүд ард үлдсэн. Тэгээд ийм муу ажиллаж байгаа Сангийн яам тэгээд өнөөдөр ямар байдалтай байгаа билээ эдийн засаг

чинь. Тэгээд эд нарын үгэнд ороод 9 сарын 15 сайн болчих юм уу. Юу яриад байгаа юм. Тэгэхээр юу гэсэн үг юм. Сая би бол хэн даргын гаргаж байгаа саналыг хүлээн зөвшөөрч байна. Энэ чинь 9 сарын 1 дээ хийгээд бэлтгэл ажлуудаа хангаад, тэр хэлэлцүүлгээ хийгээд явж байя л даа. Гишүүд ирээд л явж л байж болно шүү дээ. Энэ дээр 10 сарын 1 гэдэг дээр санал нэг байна.

2 дугаарт бол ер нь бизнесийн салбарт бол би энэ төсвийн бодлогыг бол хажуугаас нь хараад зүгээр бизнесийн салбарт юу гэж хэлдэг вэ гэхээр компани байгуулж тоглож байна гэж хэлдэг байхгүй юу. Хэт их өндөр олохгүй байгаа орлогоо биччихээд баахан зардал гаргаад, үр бүтээлгүй бол компани байгуулж тоглож байгаа. Айлын эрх хүүхдүүд юм уу, гадаадад сургууль төгсөөд ирсэн нөхөр цээжээ дэлдээд, тэгээд үрэн таран хийж байгаа хэлбэр манайд бол ерөөсөө төгс байгаа. Сүүлийн жилүүдэд манай энэ олон салбарыг манай төсөв өөрөө ерөөсөө халамжийн болгосон. Та өөрөө хэлсэн. Сүүлийн жилүүдэд 3 дахин өссөн. Бид нарын нүдэн дээр 2016 оноос хойш 3 дахин өслөө шүү дээ. 16 их наяд л ярьдаг байсан шүү дээ. Онтгойгоо адилхан. Тэгээд өнөөдөр хэд байна. 30 гараад, 40. Үгүй ээ, тэгээд энэ чинь өөрөө энэ төсвийг дагаад явж байгаа олон компаниудыг зүгээр халамжийн болгосон.

Сая өрсөлдөх чадвар гэдэг дээр би 1 зүйл хэлэхэд төсвийг дагаад яваад, төсвийн дэмжлэгийг аваад өрсөлдөх чадвартай болохгүй. Энэ бол худлаа. Тэгж байгаа улс орон гэж байхгүй. Бизнес өөрөө өрсөлдөх чадвартай болдог. Эхлээд бид нар татвар төлөгч нарыгаа өрсөлдөх чадвартай болгож байж дараа нь төрийн дэмжлэгийг ярих ёстой. Гэтэл төрийн дэмжлэг яриад энэ салбарыг зүгээр унагадаг. Зарим хүнд таалагдахгүй байгаа байх. Бодит байдал чинь энэ. Би төсөв дээр ер нь ямар саналтай байдаг вэ гэхээр бид орлогоо бага төлөвлөх ёстой. Тэр хэмжээгээрээ орлогод аваад биелэх юм бол түүгээрээ тэр төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх тэр боломж. Компани чинь ингэж ажилладаг. Хувь хүн ч гэсэн ингэдэг биз дээ. 100 төгрөгтэй хүн 500 төгрөгтэй гээд машин аваад уначихдаггүй юм байгаа биз дээ. Тэгвэл дампуурна биз дээ. Үгүй ээ, тэгэхэд манайх 100 төгрөгтэй байж байж 500 төгрөгтэй гээд явж байна шүү дээ. Энэ өөрөө үндсэн гол.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ж.Ганбаатар гишүүнд 1 минут.

Ж.Ганбаатар: Тэгээд би бол ямар саналтай байна гэхээр бол ер нь бол орлогыг бид бид бага төлөвлөх ёстой. Тэгж байж энэ төрийн данхар бүтэц чинь саарна. Тэр төсөл хөтөлбөрүүдээ гадаадын зээл тусламж юм уу юу байдаг юм түүгээрээ ямар нэгэн байдлаар явна биз. Энэ орлого бага төлөвлөснөөрөө энэ данхайсан төсөв чинь багасна. Төрийн албан хаагч нарын тоо гэх юм уу, эсвэл энийг дагасан тэр сургууль цэцэрлэг хэрэггүй. Сумуудад чинь тэр хөөцөлдлөгөө сайтай гээд байгаа таны тэр гишүүдээр сумууд чинь 1 ч удаа ашигладаггүй барилга байшин хэдэн мянга байна. Тэгээд тэр барьсан байшин чинь 3 жил, 4 жилийн дараа буцаад бараг хуучин барьсан байшингаасаа 7 дор болж байна шүү дээ. Тэгэхээр бол орлогоо маш зохистой төлөвлөх хэрэгтэй. Ингэж байж энэ чинь өрсөлдөх чадвартай, ингэж байж цаашаа явна. Өөрийгөө ярихад юу юм даа. 2024 он, 2023 онд бид бол маш зөв төлөвлөж чадсан. Өнөөдрийн төлөвлөгөөгөө хар. Ямар их алдагдалтай байна. Тэгээд одоо бол нэг баатар болчихсон юм уу, хаашаа юм. Тэгээд төсвөө тодотгоно .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн үг хэлж дууслаа. Жавхлан сайд алга байна. Гишүүд танилцуулгатай холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тэгэхдээ ер нь байна шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал дээр бол тайлбар хэлж болох юм байна лээ. Нөгөө санал хураалгаж байгаа хүн бол. Үг байхгүй. Ер нь би Заяабал гишүүний хэлээд байгаатай ч гэсэн зарчмын хувьд санал нэг юмнууд байна. Та нар бол асуудлыг гаргаж ирэхдээ сайн хандсан байна. Ингээд болохгүй байгаа юмнуудыг нэлээн олон талаас нь судлаад гаргаж ирж. Шийдэл гаргах тал дээрээ гишүүд дутуу байна гээд байгаатай би бас санал нэг байна. Жишээлбэл, бидний гол шийдэж чадахгүй байгаа нэг юм байгаа байхгүй юу. 2011 онд 2012 оны төсвийг 2 дахин нэмсэн байхгүй юу. Баярцогт Сангийн сайд байсан. Хамгийн сүүлд 2021 оны төсөв 11 их наяд байсныг 2022 онд 22 болгоод ингээд л 2024 онд 33 болгоод л явчихсан. 3 жилийн дотор 3 дахин нэмчхэж байгаа байхгүй юу. Энийг л бид нар хязгаарлах ёстой байхгүй юу. Уг нь төсвийн тогтвортой байдлын хууль гээд гаргаад л яваад байгаа боловч Тогтвортой байдлын хууль, төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд л нэмээд явчхаад байна шүү дээ. Тэгэхээр бид нар энийг л зогсоох хэрэгтэй. Ерөөсөө Герман бол яадаг юм билээ. Бүр квот тавьчхаад, Үндсэн хуульдаа хийгээд хаячихсан юм билээ. Тэрнээс цааш нэмж болдоггүй. Тэр шиг бид нар яах юм гэж. Ер нь энэ зардлыг нэмэхгүй байх юмыг л хуулийн маш чанга нөхцөлүүдийг л оруулж өгөхгүй энэ байдал үргэлжлээд л байна. Орлогоо бодитой төлөвлөхгүй байна. Зардлаа хязгааргүй нэмж байна. Төсвөө хэд дахин тэлж байна. Энэ чиглэлээр бид нар анхаарах ёстой. Түвшин гишүүн ээ үг хэлээд дууссан, асуулт асуугаад дууссан учраас би зөрчиж болохгүй болчихоод байна.

Ингээд ажлын хэсэгт баярлалаа. Та бүхэн энэ дээр нэлээн ач холбогдол өгч ажиллаж, ялангуяа төсөв боловсруулахад төсвөө хэлэлцэн батлахад үүсээд байгаа хүндрэлтэй асуудлыг, хэрэгжихэд үүсээд байгаа асуудлуудыг бас гаргаж ирсэн байна. Ялангуяа тэр төсөв дээр хуулиар бусад хуулиар төсвийг нэмдэг юмнуудыг ерөөсөө энийг болиулах хэрэгтэй байгаа. Бас харьцангуй буураад яваад л байгаа юм. Тийм тэтгэмж 6 сарын юутай нэмэх энэ тэр гээд л.

Татвар, Эрүүгийн хууль 2 дээр бол асуудал бий бий. Тэр бол жоохон ноцтой эд байхгүй юу. Ингээд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн танилцуулгыг бид нар сонслоо.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Тэгээд ажлын хэсэгт талархаж байна. Бүхий л хүрээнд бас судалгаа хийж, тулгараад байгаа асуудлыг гаргаж ирэхийг эрмэлзсэн байна. Баярлалаа.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Тэгээд энэ хуулийн төлөө санаачлаад, өргөн барьчихсан байгаа юм байна лээ. Тэгэхээр хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад сая та бүхэн бас асууж амжаагүй, хэлж чадаагүй үгээ бас хэлэх боломжтой гэдгийг хэлье. Баярлалаа. Өнөөдрийн хуралдаан дууслаа гишүүд ээ.

13.42 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ